



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 5/17

Цэнхэрмандал сум

Б.Төгөлдөрийг ажилд томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 41, 47, 48, 49 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 12 сарын 24-ний өдрийн 224 дүгээр тогтоол, 2024 оны 82 дугаар тогтоол, 2018 оны 382 дугаар тогтоол, Боловсролын сайдын 2026 оны 01 сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаал, тушаалын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус хүүхдийн цэцэрлэгт Батзоригийн Төгөлдөрийг 2026 оны 04 дүгээр сарын 09-ны өдрөөс эхлэн манаачийн ажилд томилсугай.

2. Манаач Б.Төгөлдөрийг ТҮ-1 албан тушаалын цалин 1,431,000 (Нэг сая дөрвөн зуун гучин нэгэн мянга)-н төгрөгөөр цалинжуулахыг нягтлан бодогч Д.Ганчимэгт зөвшөөрсүгэй.

3. Манаач Б.Төгөлдөрт холбогдох эд хөрөнгийг хүлээлгэн өгч, бүртгэл хөтлөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Э.Сугармаа – Арга зүйч (Өмч хамгаалах  
байнгын зөвлөлийн дарга)

Нарийн бичиг: Д.Пүрэвсүрэн - Нярав

Гишүүн: Г.Түвшинзаяа - Хөгжмийн багш (Өмч хамгаалах  
байнгын зөвлөлийн гишүүн)

4. Хуульд заасан эрх үүргээ биелүүлж, холбогдох дүрэм журмыг чанд мөрдөн цаг баримталж, батлагдсан ажлын цагт ажил үүргээ бүрэн хариуцаж хариуцлага, санаачлагатай, ёс зүйтэй ажиллахыг манаач Б.Төгөлдөрт үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ



П.ГАНТУЯА